

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/008/НА-СТА-ТЭЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням Утас: 261663 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Долгорсүрэн Утас: 261885 Цахим хаяг: dolgorsuren@audit.gov.mn Ахлах аудитор: С.Отгонхорлоо Утас: 261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД
Б.ЧОЙЖИЛСҮРЭН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.04.25 № 1621
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 79,989.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээр санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Тайлант онд нийт 1,915.2 сая төгрөгийн авлага, 596.1 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж хугацаа дууссан төсөл, арга хэмжээг улсын комиссын актаар хүлээж авсан боловч хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлээгүй, үүнээс Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 39,263.0 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэх зөвшөөрлийг аваагүй;
- Эдийн засгийн зорилтот түвшинд батлаагүй 422.8 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн;
- Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн хэсгүүдийн хамаарал бүхий бүтцийг тодорхой болгоогүйгээс өртгийн төвд хуримтлуулан бүртгэх зардал тодорхойгүй, үнэн зөв тооцоогүй;

- Хойшлогдсон хөрөнгө, өр төлбөрийн тооцоололд гадаад валютаар илэрхийлсэн өр төлбөр, ажилчдын тэтгэмжийн нөөцтэй холбоотой түр зөрүүгийн тооцооллыг хийж бүртгэсэн боловч элэгдэх хугацаа болон капиталжуулалттай холбоотой элэгдэх хөрөнгийн өртгийн ялгаанаас үүссэн түр зөрүүг бүртгээгүй.

Эдгээр зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.5-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Зөвлөл Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.2.6-д “Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, бүртгэлийг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж, хангах, хяналт тавих, бүрэн хариуцах”; 2.2.10-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний өмч бүртгэл, ашиглалтыг хариуцан хэрэгжүүлэх”; 5.4.6-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон энэ журамд заасны дагуу шийдвэрлэнэ”; 5.5.1-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЭЗҮ-г захиалагч хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ”; гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “Эрх ба үүрэг”, “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”, “Өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх зарим арга хэмжээ авах тухай” 2018 оны 324 дүгээр тогтоолыг үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 483, 2023 оны “тарифт хөнгөлөлт үзүүлэх тухай” 724 дүгээр тогтоолоор дээд хязгаараас давсан хэрэглээний тарифт 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээний хүрээнд Эрчим хүчний яамаар дамжуулж 90.5 сая төгрөгийн хөнгөлөлтийг төрөөс үзүүлсэн байна.

Засгийн газрын 2024 оны “Төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 249 дүгээр тогтоолоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 8 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн 6,749.9 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлтийн хэмжээ 2024 онд боловсруулалтаар 9,504.9 сая квт.ц болж, өмнөх оны гүйцэтгэлээс 570.6 сая квт.ц буюу 6.4 хувиар өссөн бөгөөд нийт цахилгааны 90.9 хувийг дулааны цахилгаан станцаар, 8.2 хувийг нар, салхины эх үүсвэрээр, 0.8 хувийг усан цахилгаан станцаар, 0.01 хувийг дизель цахилгаан станцаар тус тус үйлдвэрлэсэн байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд 131,100.0 сая төгрөгийн татаасыг нэмж тодотгон Эрчим хүчний сайдын 2024 оны А/200 дугаар тушаалаар компаниудад өвөлжилтийн бэлтгэл хангах, нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, импортын эрчим хүч худалдан авах, тарифын алдагдлыг бууруулах болон бусад хуримтлагдсан өр төлбөрийг үе шаттайгаар барагдуулах, компанийн санхүү, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх ажлын санхүүгийн дэмжлэгийг хуваарилан олгосон байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 632, 643 дугаар тогтоолоор хэрэглэгчийн тарифт зохих өөрчлөлтийг оруулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Эрчим хүчний рефорум хийх ажлын хүрээнд Эрчим хүчний сайдын 2024 оны А/235 дугаар тушаал, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан эрчим хүчний эх үүсвэрүүдийн үйлдвэрлэх цахилгаан эрчим хүчийг хэрэглэгчдэд хүргэхийн тулд шинээр барих, өргөтгөх шаардлагатай цахилгаан дамжуулах өндөр, нам хүчдэлийн шугам сүлжээ, дэд станцуудын хүчин чадал, байршлыг тодорхойлох, сэргээгдэх эрчим хүч-тархмал эх үүсвэрийн төслүүдийг нэгдсэн сүлжээний горим ажиллагаатай уялдуулан байршил, хүчин чадлыг тодорхой болгох хувилбарт тооцооллуудыг хийж, дүгнэлт боловсруулахаар ажилласан байна.

Төрөөс 14 мега төсөл хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрчим хүчний салбарт Таван толгойн дулааны цахилгаан станц, Эрдэнэбүрэнгийн болон Эгийн голын усан цахилгаан станц, Сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэрийг хөгжүүлэх зэрэг төслүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

 Д.ЗАГДЖАВ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	961,843,000.1	1,071,849,415.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	92,788,464.6	83,347,796.7
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	142,347,004.8	143,051,903.3
34	УРЬДЧИЛГАА	66,113,747.3	30,997,702.0
35	БАРАА МАТЕРИАЛ	193,266,654.9	120,742,024.6
36	НӨӨЦИЙН БАРАА	16,237,010.2	8,991,319.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	451,090,118.3	684,718,668.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,229,499,700.6	4,323,367,569.6
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	804,112.2	1,112,312.0
37100	Урт хугацаат хадгаламж	-	-
37200	Үнэт цаас	-	-
37300	Урт хугацаат зээл	804,112.2	1,112,312.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,228,695,588.3	4,322,255,257.6
39100	Газар	-	-
39200	Биет хөрөнгө	3,903,502,094.6	3,944,792,316.0
39300	Биет бус хөрөнгө	306,556,598.2	356,363,795.6
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	18,636,895.5	21,099,146.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,191,342,700.7	5,395,216,984.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,912,046,586.1	2,143,663,066.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	247,682,098.0	334,472,786.8
41100	Богино хугацаат үнэт цаас	-	-
41200	Богино хугацаат зээлийн өглөг	33,204,846.4	86,119,584.4
41300	Өглөг	194,065,182.0	209,388,281.5
41400	Урьдчилж орсон орлого	20,412,069.6	38,964,920.9
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,664,364,488.1	1,809,190,279.6
42100	Урт хугацаат үнэт цаас	-	-
42200	Урт хугацаат зээл	2,664,364,488.1	1,809,190,279.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,279,296,114.6	3,251,553,918.3
51	Засгийн газрын хувь оролцоо	2,279,296,114.6	3,251,553,918.3
51100	Засгийн газрын оруулсан капитал	3,271,431.5	3,271,431.5
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,683,935,234.4	1,698,637,769.1
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	374,701,682.6	403,583,781.7
51200	Хуримтлагдсан үр дүн	(654,043,978.7)	273,188,758.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	871,431,744.8	872,872,177.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,191,342,700.7	5,395,216,984.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	508,938,656.1	844,316,179.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	270,599,984.0	399,332,600.0
120	Нийтлэг татварын бус орлого	270,599,984.0	399,332,600.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	238,338,672.1	444,983,579.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	569,964,380.9	605,201,545.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	569,964,380.9	605,201,545.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	558,498,503.9	585,172,771.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,955,421.4	3,897,395.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	380,486.4	481,862.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,756.7	93,851.6
2104	Хангамж, бараа материалын зардал	88,358.6	92,092.3
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,858.4	134,608.6
2107	Томилолт, зочны зардал	14,359.1	151,079.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,481,813.6	322,465,328.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	254,441,449.8	257,856,552.9
211	ХҮҮ	-	-
212	ТАТААС	6,118,790.2	7,429,543.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,347,086.7	12,599,229.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-61,025,724.8	239,114,633.8
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	3,804,434.6	25,335,395.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,424,020.3	17,573,723.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-65,645,310.5	246,876,305.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,345,645,758.4	-	2,345,645,758.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-7,496,337.5	-	-7,496,337.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,338,149,420.9	-	2,338,149,420.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-3,365,316.9	-	-3,365,316.9
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-1,474,300.8	-	-1,474,300.8
7	Өмчид гарсан өөрчлөлт	12,300,586.7	-	12,300,586.7
8	Зарласан ногдол ашиг	-668,964.9	-	-668,964.9
9	Тайлант үеийн үр дүн	-65,645,310.5	-	-65,645,310.5
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,279,296,114.6	-	2,279,296,114.6
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,279,296,114.6	-	2,279,296,114.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	681,416,528.8	-	681,416,158.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,960,712,643.4	-	2,960,712,272.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	1,440,432.6	-	1,440,432.6
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	134,070.0	-	134,070.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	43,451,934.5	-	43,451,934.5
18	Зарласан ногдол ашиг	-1,061,468.0	-	-1,061,097.2
19	Тайлант үеийн үр дүн	246,876,305.8	-	246,876,305.8
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,251,553,918.3	-	3,251,553,918.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,756,726,894.1	3,180,352,533.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,515,575,888.2	2,736,129,201.3
120	Нийтлэг татварын бус орлого	2,515,375,888.2	2,735,879,201.3
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	200,000.0	250,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	241,151,005.9	444,223,331.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,670,308,461.2	2,865,487,669.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,670,308,461.2	2,865,487,669.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,658,842,584.2	2,845,446,599.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	395,901,435.6	430,537,516.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,137,038.3	129,019,901.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,358,394.0	49,708,256.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,468,813,558.0	1,458,283,243.7
2105	Норматив зардал	657.0	246.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,372.7	141,423.6
2107	Томилолт, зочны зардал	14,359.1	151,079.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	616,157,260.8	774,242,012.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,425,508.7	3,362,918.5
211	ХҮҮ	-	-
212	ТАТААС	6,118,790.2	7,429,543.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,347,086.7	12,611,526.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	86,418,432.9	314,864,863.9
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	2,202,307.5	2,339,844.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	373,061,305.8	387,053,336.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	373,061,305.8	387,053,336.5
2200	Дотоод эх үүсвэрээр	373,061,305.8	387,053,336.5
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-370,858,998.4	-384,713,491.7
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	304,593,988.1	60,407,959.9
14	Бусад эх үүсвэр	362,392,863.8	142,458,198.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	-	-
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	57,798,875.7	82,050,238.7
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	20,153,422.6	-9,440,667.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	72,635,042.0	92,788,464.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	92,788,464.6	83,347,796.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	468,184,128,900.00	443,612,907,020.87	24,571,221,879.13	94.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	242,170,087,200.00	240,306,278,273.94	1,863,808,926.06	99.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,273,494,200.00	6,701,286,429.14	572,207,770.86	92.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,097,499,300.00	3,825,468,937.30	272,030,362.70	93.4
210101	Үндсэн цалин	2,399,863,800.00	2,377,336,499.19	22,527,300.81	99.1
210102	Нэмэгдэл	1,056,719,600.00	749,180,696.96	307,538,903.04	70.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	391,713,300.00	371,408,363.64	20,304,936.36	94.8
210104	Урамшуулал	249,202,600.00	327,543,377.51	-78,340,777.51	131.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	549,687,400.00	481,862,060.71	67,825,339.29	87.7
210201	Тэтгэврийн даатгал	373,787,400.00	329,533,550.58	44,253,849.42	88.2
210202	Тэтгэмжийн даатгал	43,975,000.00	38,983,292.15	4,991,707.85	88.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,987,500.00	19,538,047.20	2,449,452.80	88.9
210204	Ажилгүйдлийн даатгал	21,987,500.00	18,723,664.05	3,263,835.95	85.2
210205	Эрүүл мэндийн даатгал	87,950,000.00	75,083,506.73	12,866,493.27	85.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	145,425,400.00	93,851,618.13	51,573,781.87	64.5
210301	Гэрэл, цахилгаан	107,439,200.00	70,926,437.80	36,512,762.20	66.0
210302	Түлш, халаалт	28,062,700.00	17,220,195.92	10,842,504.08	61.4
210303	Цэвэр, бохир ус	9,923,500.00	5,704,984.41	4,218,515.59	57.5
2104	Хангамж, бараа материалын зардал	106,311,700.00	90,942,206.00	15,369,494.00	85.5
210401	Бичиг хэрэг	27,001,000.00	25,103,723.00	1,897,277.00	93.0
210402	Тээвэр, шатахуун	14,731,400.00	10,000,000.00	4,731,400.00	67.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,501,100.00	32,501,100.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,230,900.00	900,000.00	2,330,900.00	27.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	28,847,300.00	22,437,383.00	6,409,917.00	77.8
2105	Норматив зардал	1,122,100.00	246,000.00	876,100.00	21.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,122,100.00	246,000.00	876,100.00	21.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	325,023,300.00	307,031,834.00	17,991,466.00	94.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	184,506,500.00	168,516,719.00	15,989,781.00	91.3
210604	Урсгал засвар	140,516,800.00	138,515,115.00	2,001,685.00	98.6
2107	Томилолт, зочны зардал	152,720,000.00	151,079,903.00	1,640,097.00	98.9
210702	Дотоод албан томилолт	152,720,000.00	151,079,903.00	1,640,097.00	98.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,740,729,400.00	1,596,668,420.00	144,060,980.00	91.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,699,890,000.00	1,561,460,465.00	138,429,535.00	91.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,325,200.00	0.00	1,325,200.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	5,403,100.00	5,391,970.00	11,130.00	99.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	341,200.00	335,703.00	5,497.00	98.4
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	-	77,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	26,960,000.00	26,960,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	2,376,200.00	1,884,282.00	491,918.00	79.3
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,356,700.00	636,000.00	3,720,700.00	14.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	154,975,600.00	154,135,450.00	840,150.00	99.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	154,975,600.00	154,135,450.00	840,150.00	99.5
212	ТАТААС	221,622,946,300.00	221,621,474,900.80	1,471,399.20	100.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	221,622,946,300.00	221,621,474,900.80	1,471,399.20	100.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	221,622,946,300.00	221,621,474,900.80	1,471,399.20	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,273,646,700.00	11,983,516,944.00	1,290,129,756.00	90.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	5,297,400.00	4,619,696.00	677,704.00	87.2

213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	5,297,400.00	4,619,696.00	677,704.00	87.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,268,349,300.00	11,978,897,248.00	1,289,452,052.00	90.3
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	53,290,000.00	20,100,000.00	33,190,000.00	37.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,156,222,400.00	11,901,263,254.00	1,254,959,146.00	90.5
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	58,836,900.00	57,533,994.00	1,302,906.00	97.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	226,014,041,700.00	203,306,628,746.93	22,707,412,953.07	90.0
220001	Барилга байгууламж	220,953,341,700.00	198,494,159,604.93	22,459,182,095.07	89.8
221001	Их засвар	240,700,000.00	234,041,952.00	6,658,048.00	97.2
222001	Тоног төхөөрөмж	4,820,000,000.00	4,578,427,190.00	241,572,810.00	95.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	468,184,128,900.00	443,612,907,020.87	24,571,221,879.13	94.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	468,184,128,900.00	443,612,856,296.87	24,571,272,603.13	94.8
310001	Улсын төсвөөс санхүүжих	468,184,128,900.00	443,612,856,296.87	24,571,272,603.13	94.8
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	32	32	-	100.0
610001	Төсвийн байгууллага	32	32	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	110.00	101.00	9	91.8
620001	Удирдах ажилтан	18.00	18.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	80.00	71.00	9	88.8
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00	-	100.0

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 121,853.3 сая төгрөгийн 67 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 79,989.5 сая төгрөгийн 207 зөрчил² илэрснээс, 189.1 сая төгрөгийн төлбөрийн 45 акт тогтоож, 74,539.6 сая төгрөгийн 87 албан шаардлага хүргүүлж, 5,260.9 сая төгрөгийн 75 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 79,989.5 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд харьяа 32 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 28 байгууллагад дүгнэлт гаргаж, Багануур цахилгаан станц ТХН, Таван толгой дулааны цахилгаан станц ТӨХХК, Эрчим хүчний эдийн засгийн үндэсний хүрээлэн ТӨҮГ, Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд Өөрчлөлтгүй 25, Хязгаарлалттай 3 дүгнэлт өгсөн.

5.2 ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

Аудитаар нийт 3 зөрчил илэрснээс харьяа байгууллагуудад тавих дотоод хяналтыг сайжруулах 1 албан шаардлага, зөрчлийг арилгах 2 зөвлөмж өглөө.

5.3 АЛБАН ШААРДЛАГА

Илрүүлэлт 1. Эрчим хүчний яамны дотоод болон бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байгаагаас сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 79,989.5 сая төгрөгийн 206 зөрчил илрүүлж, нөхөн төлүүлэхээр 189.1 сая төгрөгийн 45 төлбөрийн акт тогтоож, 74,539.6 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх 86 албан шаардлага, 5,260.9 сая төгрөгийн 75 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.6.1-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, болон Зөвлөл Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна”, 16 дугаар зүйлийн 16.5.6-т “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.1-т “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг сайжруулж, санхүүгийн үйл ажиллагаанд гарч буй зөрчлийг 20.0-оос доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, өмнөх онд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Эрчим хүчний яамны хөрөнгө оруулалт

¹Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

²Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт 2. Өмнөх оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй, тайлант онд хэрэгжиж хугацаа дууссан 92,143.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 63 төсөл, арга хэмжээг улсын комиссын актаар хүлээж авсан боловч төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагад шилжүүлээгүйгээс, холбогдох байгууллагад шийдвэрлээгүй 39,263.0 сая төгрөгийн хөрөнгө байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.2.6-д “Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, бүртгэлийг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулж, хангах, хяналт тавих, бүрэн хариуцах”; 2.2.10-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний өмч бүртгэл, ашиглалтыг хариуцан хэрэгжүүлэх”; 5.4.6-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон энэ журамд заасны дагуу шийдвэрлэнэ”; 5.5.1-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЭЗҮ-г захиалагч хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ”; Монгол Улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19 дүгээр зүйлийн 19.1-т “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын комиссын актаар хүлээн авч ашиглалтад орсон барилга, байгууламжийн хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль, журмын дагуу тухай бүрд шийдвэрлээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Эрчим хүчний Эдийн засгийн хүрээлэн

Илрүүлэлт 3. Өглөгийн дансны 5,354.3 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.4 Зөвлөмж

Барьцаа хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 1. Олон жилийн насжилттай 2013-2021 онд үүссэн гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагад буцаан олгоогүй 154.1 сая төгрөгийн барьцааны үлдэгдэл бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2013-2021 онд барьсан барилгын гэрээний хугацаа дууссан, олон жилийн насжилттай барьцаа хөрөнгийн асуудлыг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, чөлөөлөх арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөв.

Өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт 2. Шүүхийн маргаантай 3 ажлын барьцааны 461.9 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох асуудлыг шийдвэрлэж, тайлант онд үүссэн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулж байх зөвлөмж өгөв.

Багануур цахилгаан станц төсөл

Илрүүлэлт 3. Байгууллагад өгөх 0.7 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

25	Хөвсгөл дулааны цахилгаан станц ТӨХК	3	209.8	2	159.8	1	49.9	3	209.8				
26	Эгийн голын усан цахилгаан станц	1	16,475.5			1	16,475.5	1	16,475.5				
27	Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК	0											
28	Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	0											
29	Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК	4	7,215.5	1	0.0	3	7,215.2	4	7,215.5				
30	Эрчим хүчний үндэсний хүрээлэн ТӨҮГ	1	5.4			1	5.4	1	5.4				
31	Эрчим хүчний яам	2	4.1			2	4.1	2	4.1				
32	Хөрөнгө оруулалт	-	-										
	ДҮН	67	121,853.3	8	307.4	59	121,545.7	66	121,850.4	1	3.0	1	3.0
33	Эрчим хүчний сайд												
	ДҮН	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	НИЙТ ДҮН	67	121,853.3	8	307.4	59	121,545.7	66	121,850.4	1	3.0	1	3.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Алтай-Улиастай эрчим хүчний систем ТӨХК	32	262.0	10	18.9	20	236.5	2	6.6				
2	Амгалан дулааны станц ТӨХК	3	11.0	1	9.2			2	1.8				
3	Багануур дулааны станц ТӨХК	8	119.7			6	114.5	2	5.2				
4	Багануур цахилгаан станц ТХН	1	0.8					1	0.8				
5	Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан станц ТӨХК	6	1,024.9			3	192.1	3	832.8				
6	Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК	2	11.9					2	11.9				
7	Дархан дулааны цахилгаан станц ТӨХК	3	23.6	2	19.4	1	4.2						
8	Дархан дулааны сүлжээ ТӨХК	5	14.0	4	14.0			1					
9	Даланзадгад дулааны цахилгаан станц ТӨХК	2	0.8					2	0.8				
10	Дулааны 2-р цахилгаан станц ТӨХК	0	-										
11	Дулааны 3-р цахилгаан станц ТӨХК	8	242.7	2	6.0	5	230.8	1	5.9				

12	Дулааны 4-р цахилгаан станц ТӨХК	27	21,132.8	1	12.2	10	21,060.2	16	60.3				
13	Дулаан шарын гол ТӨХК	1	0.8	1	0.8								
14	Диспетчерийн үндэсний төв	4	671.8			3	671.8	1					
15	Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК	9	603.4	2	26.0	3	226.1	4	351.2				
16	Таван толгой дулааны цахилгаан станц ТӨХК	0	-										
17	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	10	5,914.7			5	5,658.0	5	256.7				
18	Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК	3	107.0	1	22.6			2	84.4				
19	Улаангомьын хоёр дугаар дулааны станц ТӨХК	0	-										
20	Налайхын дулааны станц ТӨХК	4	9.6	2	5.6	1	2.1	1	1.8				
21	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	14	3,684.7	2	17.0	8	1,530.8	4	2,136.9				
22	Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	2	0.7					2	0.7				
23	Замын үүдийн дулааны станц ТӨҮГ	4	17.7	2	4.7	1	9.0	1	4.0				
24	Ховд дулааны цахилгаан станц ТӨХК	1	6.1					1	6.1				
25	Хөвсгөл дулааны цахилгаан станц ТӨХК	3	3.2	2	3.2	1	-						
26	Эгийн голын усан цахилгаан станц	3	4.1			1	1.7	2	2.4				
27	Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК	17	741.4	7	26.2	6	705.6	4	9.6				
28	Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	16	776.4	6	3.1	2	91.9	8	681.4				
29	Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК	6	542.5			4	542.5	2					
30	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ	1	5.4			1	5.4						
31	Эрчим хүчний яам	8	4,176.9			4	3,993.4	4	183.5				
32	Хөрөнгө оруулалт	3	39,879.1			1	39,263.1	2	616.0				
	ДҮН	206	79,989.6	45	189.1	86	74,539.7	75	5,260.9	-	-	-	-
33	Эрчим хүчний сайд	1	-			1	-						
	ДҮН	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
	НИЙТ ДҮН	207	79,989.6	45	189.1	87	74,539.7	75	5,260.9	-	-	-	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй шалгагдагч 8 байгууллагад 2,513.6 сая төгрөгийн нийцлийн холбоотой зөрчил илэрснээс 1,711.2 сая төгрөгийн зөрчил арилгуулах 3 албан шаардлага хүргүүлж, 744.8 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 802.4 сая төгрөгийн 5 зөвлөмж, мөн бусад хууль тогтоомжтой холбоотой 72,474.0 сая төгрөгийн 49 нийцлийн холбоотой зөрчил илэрснээс 27.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 7,538.5 сая төгрөгийн 20 албан шаардлага, 64,908.3 сая төгрөгийн 28 зөвлөмж хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Д.д	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Алтай-Улиастай эрчим хүчний систем ТӨХК								
2	Амгалан дулааны станц ТӨХК								
3	Багануур дулааны станц ТӨХК								
4	Багануур цахилгаан станц ТХН								
5	Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан станц ТӨХК								
6	Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК								
7	Дархан дулааны цахилгаан станц ТӨХК								
8	Дархан дулааны сүлжээ ТӨХК	1	134.6					1	134.6
9	Даланзадгад дулааны цахилгаан станц ТӨХК	1	102.4					1	102.4
10	Дулааны 2-р цахилгаан станц ТӨХК								
11	Дулааны 3-р цахилгаан станц ТӨХК								
12	Дулааны 4-р цахилгаан станц ТӨХК	1						1	-
13	Дулаан шарын гол ТӨХК								
14	Диспетчерийн үндэсний төв								
15	Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК								
16	Таван толгой дулааны цахилгаан станц ТӨХК								
17	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК								
18	Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК								
19	Улаангомьн хоёр дугаар дулааны станц ТӨХК								
20	Налайхын дулааны станц ТӨХК								
21	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК	2	1,467.0			1	901.6	1	565.4
22	Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК								
23	Замын үүдийн дулааны станц ТӨҮГ								
24	Ховд дулааны цахилгаан станц ТӨХК								
25	Хөвсгөл дулааны цахилгаан станц ТӨХК								
26	Эгийн голын усан цахилгаан станц	1	809.6			1	809.6		
27	Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК	1						1	-
28	Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК								
29	Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК								
30	Эрчим хүчний үндэсний хүрээлэн ТӨҮГ								
31	Эрчим хүчний яам	1				1	-		
32	Хөрөнгө оруулалт								
	Дүн	8	2,513.6	-	-	3	1,711.2	5	802.4
33	Эрчим хүчний сайд								
	Дүн	-	-	-	-	-	-	-	-
	Нийт дүн	8	2,513.6	-	-	3	1,711.2	5	802.4

Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
1	Алтай-Улиастай эрчим хүчний систем ТӨХК	4	34.9			2	24.0	2	10.9
2	Амгалан дулааны станц ТӨХК	4	167.7			3	167.7	1	
3	Багануур дулааны станц ТӨХК	1				1	-		
4	Багануур цахилгаан станц ТХН	1	-					1	-
5	Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан станц ТӨХК	3	735.0	1	27.2	1	364.4	1	343.3
6	Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК	1	0.2					1	0.2
7	Дархан дулааны цахилгаан станц ТӨХК								
8	Дархан дулааны сүлжээ ТӨХК								
9	Даланзадгад дулааны цахилгаан станц ТӨХК	2	33.8			1	-	1	33.8
10	Дулааны 2-р цахилгаан станц ТӨХК								
11	Дулааны 3-р цахилгаан станц ТӨХК	1	-					1	-
12	Дулааны 4-р цахилгаан станц ТӨХК	8	14.4			2	10.5	6	3.9
13	Дулаан шарын гол ТӨХК								
14	Диспетчерийн үндэсний төв	2				1		1	
15	Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК								
16	Таван толгой дулааны цахилгаан станц ТӨХК	3	64,246.1					3	64,246.1
17	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	5	6,847.5			5	6,847.5		
18	Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК								
19	Улаангомьн хоёр дугаар дулааны станц ТӨХК	1	124.4			1	124.4		
20	Налайхын дулааны станц ТӨХК	2	255.1					2	255.1
21	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК								
22	Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК								
23	Замын үүдийн дулааны станц ТӨҮГ								
24	Ховд дулааны цахилгаан станц ТӨХК	1	-					1	-
25	Хөвсгөл дулааны цахилгаан станц ТӨХК	2				1		1	
26	Эгийн голын усан цахилгаан станц								
27	Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК								
28	Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК								
29	Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК	3	15.0			2		1	15.0
30	Эрчим хүчний үндэсний хүрээлэн ТӨҮГ	1	-					1	-
31	Эрчим хүчний яам	1	-					1	-
32	Хөрөнгө оруулалт	1	-					1	-
	Дүн	47	72,474.0	1	27.2	20	7,538.5	26	64,908.3
33	Эрчим хүчний сайд	2	-					2	-
	Дүн	2	-	-	-	-	-	2	-
	Нийт дүн	49	72,474.0	1	27.2	20	7,538.5	28	64,908.3